

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬ.

I. Оршил

1996 онд батлагдсан Хүүхдийн эрхийн тухай хууль нь хүүхэд хамгааллын харилцааг бүрэн тодорхойлж зохицуулаагүй байна.

Хорь шахам жил хэрэгжиж байгаа Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль нь материаллаг шинжтэй хууль бөгөөд хүүхдийн хамгаалагдах эрхийн хэрэгжилтийг хангах, хүүхэд хамгааллын төрөл бүрийн үйлчилгээ, түүнийг үзүүлэх тогтолцооны эрх зүйн зохицуулалт, хариуцлагыг нарийвчлан тодорхойлсон, илүү процессийн шинжтэй зохицуулалт үгүйлэгдэж байсан.

Хүүхэд, ялангуяа бага насандаа хайр халамж, гэр бүлийн орчноор дутагдсан, байнгын хүчирхийлэл, үл хайхрах байдал дунд өссөн хүүхдүүдийн тархи болон биеийн өсөлт хөгжилд ихээхэн саатал учирдаг. Тэд оюуны чадвар муу, зан авирын доголдолтой, сэтгэл гутралтай, нийгэмд биеэ авч явах чадвар муутай, өөртөө итгэлгүй хүн болон өсдөг байна.

Хэрэв хүүхдийн хамгаалуулах эрхийг хангаж чадахгүй бол үр дагавар нь хүүхэд бие махбод, сэтгэл санааны гэмтэл бэртэл авах, өвчлөх, биеийн болон сэтгэцийн хөгжил, төлөвшил нь хоцрогдох, сургууль завсардах, өсвөр насандаа жирэмслэх, гэр бүлийн халамж асрамжаас гадуур гудамжинд амьдрах, улмаар амь зогоохын эрхээр хөдөлмөр эрхлэх, мөлжлөгт өртөх, худалдагдах, хууль зөрчих, гэмт хэрэг үйлдэх, архи, тамхи, мансууруулах бодист донтох, амиа хорлох зэрэг нийгмийн сөрөг үзэгдэлд өртдөг байна.

Иймд гэр бүлд түшиглэсэн асрамж халамжийн үйлчилгээний шинэчлэлийн агуулга, хэлбэрийг хуульчлан тодорхойлох шаардлагатай болсон гэж хууль санаачлагч үзжээ.

Хүүхэд аливаа хэлбэрийн хүчирхийлэлд өртөх, садар самуун, доромжлол, басамжлал, гүтгэлэг, хүн худалдаалах зэрэг хууль бус үйдэлд өртсөөр байна. Тухайлбал, 2-14 насны нийт хүүхдийн 46 хувь нь судалгаанаас өмнөх нэг сарын хугацаанд гэр бүлийн гишүүдийн зүгээс сэтгэл зүйн болон бие махбодийн шийтгэлийг ямар нэгэн байдлаар амссан байна. Хөгжлийн бэрхшээлтэй 37000 хүүхдийн 46,6 хувь нь үе тэнгийнхэндээ шоолуулж дээрэлхүүлдэг. Хоёр жилийн дотор бусдад зодуулснаас болж 5129 хүүхэд гэмтлийн эмнэлэгт ирж, эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Хөдөлмөр эрхэлж байгаа 5-17 насны хүүхдийн тоо өсөж буйн зэрэгцээ зарим тохиолдолд тэдний хөдөлмөрийн нөхцөл нь хүүхдийн эдийн засгийн аливаа мөлжлөг, тэвчишгүй хүнд хөдөлмөрөөс хамгаалуулах эрхийг зөрчиж байна. Улсын хэмжээнд нийт халамж асрамжийн 34 төвд 998 хүүхэд амьдарч байгаагийн 60,0 хувь нь ядуугаас, 34,0 нь хүчирхийллийн улмаас гэр орноосоо дайжсан байна.

Хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагуудын тогтолцоо нь хүртээмжтэй, үр өгөөжтэй ажиллах нөхцлийг бүрдүүлж чадахгүй байна. Хүүхэд хамгааллын үйл ажиллагаан дахь шүүхийн оролцоо сул, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих төрийн, мэргэшсэн хяналтын механизм бүрдээгүй байна. Цөөн тооны төрийн болон төрийн бус байгууллага өөрсдийн хязгаарлагдмал нөөцөөр төв суурин газруудад хүүхэд, гэр бүлд нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлж байгаа ч хүртээмж нь хангалтгүй, хөдөө орон нутагт хүүхэд хамгааллын асуудал орхигдсон хэвээр байна.

Хүүхдийн амьдарч буй орчинд сум, хороо, сургууль, эрүүл мэндийн, цагдаагийн байгууллагын болон хөгжлийн бусад байгууллагын ажилтнууд ажиллаж байгаа боловч хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр мэргэшсэн ажилтны хувь тодорхой бус, дагнасан ажилтангүй. Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын ажилтныг бэлтгэх, мэргэшүүлэх, арга зүйн хувьд тогтмол удирдлагаар хангах талаарх харилцаа эрх зүйн хувьд зохицуулалтгүй байна. Хүүхэдтэй ажилладаг хүмүүсийн ёс зүй ч эмзэг асуудлын нэг болсон.

Хүүхдийн нэр төр, эрх, эрх чөлөөг хүндэтгэж, тэднийг ялгаварлан гадуурхах, сэтгэл санаа, бие махбодийн шийтгэл оногдуулах, аливаа хэлбэрийн дарамтаас хамгаалах эрх зүйн орчин бүрэн бүрдээгүй байна.

Хүүхдийн эрхийн зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авах төрөл бүрийн арга, хянан шийдвэрлэх онцлог механизм хязгаарлагдмал, хүүхдийн эрх зөрчигчид хүлээлгэх хариуцлага сул байна.

Нийгмийн хөгжлийн шаардлагаар хүүхэд бага, дунд сургуульд суралцах зорилгоор хөдөө орон нутгаас хот, суурин газарт шилжих, эцэг, эх ньхот, суурин газар, гадаад улсад ажил эрхлэх байдал түгээмэл байгаагаас үүдэн хүүхэд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн байнгын хяналтаас гадуур өсч хүмүүжих үзэгдэл ихэссээр байна. Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр 18 хүртэлх насны хүүхдүүдийн 16.6 хувь нь эцэг, эхгүй болон эцэг эхээсээ тусдаа амьдарч байна. Мөн түүнчлэн ямар нэгэн асран хамгаалагчгүй 15 хүртэлх насны 281 хүүхэд тоологдсоны дийлэнх буюу 228 хүүхэд нь хотынх байсан байна. Энэ нь бага тоо мэт боловч хараа хяналтгүй хүүхэд байсаар байгаагийн нотолгоо юм. Суурь боловсрол эзэмших насандаа хүүхэд хөдөлмөр эрхлэх нь түгээмэл байгаа нь хүүхдийн эдийн засгийн аливаа мөлжлөг, тэвчишгүй хүнд хөдөлмөрөөс хамгаалуулах эрх зөрчигдөх нөхцөлийг бүрдүүлж байна.

Хүчин төгөлдөр мөрдөж буй Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийг Хүүхдийн эрхийн тухай хууль болгон шинэчлэн найруулахын зэрэгцээ хүүхдийн хамгаалуулах эрхийг төрөөс баталгаатай хангахтай холбоотой процессийн шинжтэй зохицуулалтыг түлхүү анхаарч, олон улсын нийтлэг жишиг, хөгжингүй болон хөгжиж байгаа орнуудын туршлагыг харгалзан хууль санаачлагчийн зүгээс Хүүхэд хамгааллын тухай хуулийг шинээр боловсруулж батлуулсан байна.

Хүүхэд хамгааллын харилцаанд төр, аж ахуйн нэгж, байгууллага, аливаа хувь хүний энэ хуулийн дагуу авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь хүүхдийн дээд ашиг сонирхолд нийцсэн байх, хүүхдийн нас, бие, сэтгэхүйн хөгжлийн онцлогийг үндэслэн, түүний санал, хүсэлтийг харгалзан үзэх зарчмыг баримталж, тэдгээрийг хангах хууль зүйн механизмыг бүрдүүлсэн процессийн шинжтэй үндсэн зохицуулалтуудыг хуульд тусгасан.

Гэр бүл, нийгмийн хүрээн дэх хүүхэд хамгааллын үндсэн зохицуулалтыг хуульд тусгаж, эцэг эх нь хүүхдийн амь, амьдрал, хөгжлийг бусад оролцогчдоос тэргүүн ээлжинд хамгаалах үүрэгтэй. Гэр бүл, эцэг эх нь хүүхдээ хамгаалах үүргээ биелүүлээгүй буюу биелүүлэх боломжгүй бол төрийн зүгээс хүүхэд хамгааллын харилцаанд оролцоно.

Хүүхэд сурч боловсрох, хөдөлмөр эрхлэх, эрүүл мэндээ хамгаалуулах, хүүхдийн чөлөөт цаг, тоглож наадах эрхээ эдлэх нөхцөл, хүүхдийн дээд ашиг сонирхлын үүднээс тэдгээрт тавигдах хязгаарлалтыг хуульчлан тогтоож, мөн хүүхдийн хувийн нууцыг хамгаалах, хэвлэл, мэдээллийн хэрэгслийн үүрэг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хамгааллын онцлог зохицуулалтыг тусгасан. Хүүхдийн эрхийн зөрчлийг үл тэвчих, мэдээлэл заавал өгөх үүрэг бүхий этгээдийг тодорхойлсон.

Хууль 6 бүлэг, 25 зүйлтэй бөгөөд энэ хуулиар хүүхэд хамгааллын зарчим, төрийн чиг үүргийг тодорхойлж, нийгэм, гэр бүл, шүүн таслах, хууль сахиулах байгууллагын хүрээн дэх хүүхэд хамгааллын онцлог, хүүхэд хамгааллын үйлчилгээ, түүнийг үзүүлэх журам, хүүхдийг үл хайхрах, хүүхэдтэй холбоотой эрх, үүргээ урвуулан ашиглах, зүй бусаар харьцах, мөлжлөгийн аливаа хэлбэр (хүүхдийн эсрэг хүчирхийлэл, дарамт, мөлжлөгийн бүх хэлбэр)-ээс урьдчилан сэргийлэх, хамгаалахтай холбогдон үүсэх харилцаа, шүүн таслах, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх, мэдээллээр хангах зэрэг хүүхэд хамгааллын онцлог бөгөөд нийтлэг зохицуулалтыг тусгажээ.

Хүүхэд хамгааллын тухай хууль батлагдсантай холбогдуулж Хөдөлмөрийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай зэрэг нийт 8 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдөр Хүүхэд хамгааллын тухай хууль, түүнийг дагалдан гарсан зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж, Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2016 оны 03 дугаар сарын

04-ний өдрийн 09 дугаарт нийтэлсэн ба энэхүү хууль 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

Иймд Хүүхэд хамгааллын тухай хуулиас цагдаагийн байгууллага, алба хаагч мэдвэл зохих зүйл, заалтаас түүвэрлэн энэхүү мэдээллийг боловсрууллаа.

Хүүхэд хамгааллын тухай хуулийг бүрэн эхээр нь www.legalinfo.mn/law/details/11119?lawid=11119 цахим сайтаас дэлгэрэнгүй үзнэ үү.

II.Нэгдүгээр бүлэг Нийтлэг үндэслэл

1.Хуулийн зорилт /1 дүгээр зүйл/

Энэ хуулийн зорилт нь хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо, оролцогч талуудын харилцааг тодорхойлж, хүүхдийг үл хайхрах байдал, дарамт, мөлжлөг, хүчирхийллийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2.Хүүхэд хамгааллын зарчим, тогтолцоо /2 дугаар зүйл/

1.Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүүхэд хамгааллын үндсэн зарчим, стандартыг удирдлага болгоно.

2.Хүүхэд хамгаалал нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэрээс, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх зорилготой олон талт, цогц, мэргэшсэн үйл ажиллагаанаас бүрдэнэ.

3.Хүүхэд хамгаалал гэр бүл төвтэй, дагнасан, шуурхай, тэгш, хүртээмжтэй, үр дүнтэй байна.

4.Хүүхэд хамгааллын тогтолцоо Хүүхдийн эрхийн тухай хуульд заасан оролцогч талуудаас авч хэрэгжүүлэх бодлого, хамтын ажиллагаа, цогц үйлчилгээ, статистик мэдээлэл, санхүү төсөв, мэргэшсэн хүний нөөц зэргээс бүрдэнэ.

5.Хүүхдэд тусламж, үйлчилгээ үзүүлэх, хамгаалах талаар Монгол Улсын хууль тогтоомжид тусгайлан заасан тохиолдолд тухайн үйлчилгээ, үйл ажиллагаа, арга хэмжээ нь хүүхэд хамгааллын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болно.

6.Хүүхэд, өсвөр насны хүнийг халамжлах, эмчлэх, удирдан чиглүүлэх, тэдэнд боловсрол олгох үүрэг хүлээсэн эцэг, эх, асран хамгаалагч, бусад хүн тэднийг хүмүүжүүлэх, алдаатай зан авирыг нь засахдаа бие махбодийн болон доромжлон гутаасан бүх төрлийн шийтгэлийн арга хэрэглэхийг хориглоно.

3.Хуулийн үйлчлэх хүрээ /3 дугаар зүйл/

1.Энэ хууль Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлчилнэ.

2.Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд Монгол Улсын хилийн гадна байгаа хүүхэд, түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчид энэ хуульд заасан тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

3.Монгол Улсын иргэн төрсөн цагаас эхлэн 18 нас хүртэл, эсхүл Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд 18 наснаас дээш 21 хүртэл насны хүнд энэ хуульд заасан тусламж, үйлчилгээг үзүүлж болно.

4.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт /4 дүгээр зүйл/

- “Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд”
 - эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин нь алдагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхдийг;

- “Нийгмийн ажилтан”
 - баг, хорооны, сургуулийн, нийгмийн халамжийн, эрүүл мэндийн, бусад салбарт ажиллаж байгаа нийгмийн ажил, үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий мэргэжилтэн, ажилтан, албан тушаалтныг;

- “Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо”
 - гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэж, мөрдөн шалгагдаж байгаа, эсхүл гэмт хэргийн гэрч, хохирогч болсон, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагын төлөөлөл бүхий орон нутгийн нэгжийг;

- “Хууль зөрчсөн хүүхэд”
 - гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэн, мөрдөн шалгагдаж байгаа, эсхүл зөрчил үйлдэж шийтгэгдсэн, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж, албадлагын арга хэмжээ авагдсан, сургалт хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхдийг;

- “Хамтарсан баг”
 - гэр бүлийн болон бусад орчинд үйлдэгдсэн хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлэх анхан шатны нэгжийг;

- “Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ”
 - эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангах, дэмжих, холбон зуучлах, нийгмийн харилцаанд дасган зохицуулах, гэр бүлд нь эргэн нэгтгэх үе шат бүхий үйл ажиллагааг;

- “Хүүхдийн эрхийн ажилтан”
 - хүүхдийн эрхийн улсын байцаагчийн эрх бүхий ажилтан, албан тушаалтныг;

- “Хүүхдийн хүчирхийлэл”

эсрэг

- санаатай эсхүл санамсаргүйгээр хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжил, бие махбод, сэтгэл санаанд хор хохирол учруулах үл хайхрах байдал, бэлгийн зүй бус үйлдэл болон бие махбодийн шийтгэл, сэтгэл санааны дарамтыг.

III.Хоёрдугаар бүлэг

Гэр бүл, нийгэм дэх хүүхэд хамгаалал

5.Гэр бүл дэх хүүхэд хамгаалал /5 дугаар зүйл/

1.Эцэг, эх, гэр бүлийн гишүүд, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхэдтэй холбоотой эрх, үүргээ урвуулан ашиглах, хүүхдийг үл хайхрах, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэр, аливаа гэмт хэрэг, зөрчлөөс хамгаалах арга хэмжээг авна.

2.Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд өсч хөгжих нөхцөлийг бүрдүүлэхийн тулд хуульд заасны дагуу эвлэлдэн нэгдэх, шаардлага, өргөдөл, гомдол, мэдээлэл гаргаж, түүнийг шийдвэрлүүлэх замаар хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.

3.Гэр бүлийн орчинд хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх яаралтай тусламж, үйлчилгээг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд¹ заасны ¹дагуу үзүүлнэ.

4.Эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, хамаатан садан, багш сурган хүмүүжүүлэгч нь хүүхдийг өсгөн хүмүүжүүлэх, боловсрол олгох, асран хамгаалахдаа хүчирхийллээс ангид хүмүүжлийн арга хэрэглэнэ.

6.Эрүүл мэндийн үйлчилгээн дэх хүүхэд хамгаалал /7 дугаар зүйл/

1.Эрүүл мэндийн ажилтан ажил, үүргээ гүйцэтгэх явцдаа эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн тохиолдолд хүүхдийн асуудал эрхэлсэн орон нутгийн ажилтан, албан тушаалтан, эсхүл цагдаагийн байгууллагын алба хаагчид заавал мэдээлнэ.

2.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ хүүхдийн, түүний гэр бүл, хувийн нууцад хамаарах мэдээллийг хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд байгууллага, албан тушаалтан, хувь хүнд мэдээлэхийг хориглох бөгөөд задруулснаас үүдэн гарах үр дагаврыг өөрөө хариуцна.

3.Эрүүл мэндийн байгууллага эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хуульд заасны дагуу үзүүлнэ.

7.Хэвлэл, мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгаалал /8 дугаар зүйл/

1.Эцэг, эх, асран хамгаалагч гэр бүлийн орчинд, багш, сургуулийн ажилтан сургуулийн орчинд, хуулиар үүрэг хүлээсэн төрийн байгууллага, хуулийн этгээд бусад орчинд өөрсдийн эрх, үүргээ хэрэгжүүлэх замаар хүүхдийг түүний хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд, сөрөг нөлөө үзүүлэхүйц тоглоом мэдээ, мэдээлэл зар сурталчилгаа, цахим сүлжээнээс хамгаална.

2.Харилцаа холбооны зохицуулах хороо, цагдаагийн төв байгууллага хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц тоглоом, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгаа, цахим сүлжээнээс хүүхдийг хамгаалах талаар зөвлөмж, зааварчилгааг олон нийтэд тогтмол мэдээлж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллана.

¹ “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2004 он. №23.

3.Хүүхдэд зориулсан мэдээ, мэдээлэл нь хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй гэж үзсэн иргэн, хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгч, хүүхдийн эрхийн ажилтан энэ тухай гомдол, мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хандан шийдвэрлүүлнэ.

4.Сонин хэвлэл, телевиз, радио, цахим сүлжээ ашиглаж, хүүхдийн хувийн нууцад халдаж дуу, дуу-дүрсний, дүрсний бичвэр, гэрэл зураг тараасан, эсхүл гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж мэдээлсэн, олны өмнө гутаасан ажилтан, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

5.Арван зургаан насанд хүрээгүй хүүхэд бусад хүүхдийнхээ эсрэг хийсэн энэ зүйлийн 8.4-т заасан үйлдлээс үүсэх хохирол, хор уршгийг түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хуульд заасны дагуу хариуцна.

6.Интернэтийн орчинд эрх эзэмшиж байгаа иргэн, хуулийн этгээд хүүхдэд зориулсан тусгай багцын үйлчилгээтэй байх бөгөөд үйлчилгээний гэрээ байгуулахдаа тухайн этгээдийн асран хамгаалалд 18 нас хүрээгүй хүүхэд байгаа эсэхийг заавал асууж, насанд хүрэгчдэд зориулсан тусгай сувгийн үйлчилгээг хэрэглэх эсэхийг тохиролцоно.

8.Олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээн дэх хүүхэд хамгаалал /9 дүгээр зүйл/

1.Худалдаа үйлчилгээ, олон нийтийг хамарсан арга хэмжээ, жагсаал цуглаан, замын хөдөлгөөн, хүүхэд оролцсон шалгалт, уралдаан тэмцээний үед хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх үүргийг зохион байгуулагч болон оролцогч талууд ханган ажиллана.

2.Энэ зүйлийн 9.1-д заасан арга хэмжээ, үйлчилгээг зохион байгуулагч хууль, захиргааны хэм хэмжээний акт, гэрээ хэлцлээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас хүүхдийн амь нас, эрүүл мэндэд хохирол учрах нөхцөл бүрдсэн, эсхүл хохирол учирсан бол холбогдох хуульд заасан хариуцлага хүлээнэ.

3.Энэ зүйлийн 9.1-д заасан арга хэмжээ, үйлчилгээний үед хүүхдийн эрх зөрчигдсөн гэж үзсэн хувь хүн, хуулийн этгээд орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн байгууллага, албан тушаалтанд, эсхүл *цагдаагийн байгууллагад* амаар болон бичгээр мэдэгдэнэ.

4.Олон нийтийн үйлчилгээ, арга хэмжээний үед хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай² хуулиар зохицуулна.

IV.Гуравдугаар бүлэг Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ

9.Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ /10 дугаар зүйл/²

1.Эрсдэлт нөхцөлд байгаа, гэмт хэргийн хохирогч болсон, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, ял шийтгүүлж, албадлагын арга хэмжээ авагдсан, сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь тусалж, дэмжих чиглэлээр дараахь хариу үйлчилгээ үзүүлнэ:

- 1.1.мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах;
- 1.2.нөхцөл байдлын үнэлгээ хийх;
- 1.3.аюулгүй байдлыг хангах;
- 1.4.дэмжих, холбон зуучлах;
- 1.5.хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээ үзүүлэх;
- 1.6.гэр бүлд нь эргэн нэгтгэх.

² “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль”. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 1998 он. №01.

2.Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг төрийн байгууллага эсхүл тухайн чиглэлээр мэргэшсэн иргэн, магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээд төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх замаар үзүүлнэ.

3.Хүүхэд хамгааллын чиглэлээр үйлчилгээ үзүүлж байгаа төрийн байгууллага болон хуулийн этгээд тусгайлан бэлтгэгдэж, мэргэшсэн хүний нөөцтэй байна.

4.Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас магадлан итгэмжлэгдсэний үндсэн дээр үйл ажиллагаа явуулах бөгөөд уг журмыг хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

10.Мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах /11 дүгээр зүйл/

1.Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн талаар эсхүл эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар ирүүлсэн мэдээ, мэдээллийг нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан, хууль сахиулагч хүлээн авч шалгах, эсхүл шаардлагатай арга хэмжээг хуульд заасны дагуу авна.

2.Энэ зүйлд заасан мэдээ, мэдээллийг хүлээн авах, илрүүлэх зорилгоор яаралтай тусламжийн 24 цагийн утас ажиллуулж болно.

3.Хүүхдийн эрхийн зөрчлийн талаар ирүүлсэн мэдээ, мэдээлэл гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй бол хуульд заасан үндэслэл, журмын дагуу шалган шийдвэрлэх бөгөөд тухайн асуудлыг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо болон орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн байгууллагад заавал мэдэгдэнэ.

4.Энэ зүйлд заасны дагуу ирүүлсэн мэдээ, мэдээллийг хүлээн авсан ажилтан, албан тушаалтан тухайн нөхцөл байдлыг газар дээр нь үнэлж, холбогдох тэмдэглэлийг нийгмийн ажилтан, хамтарсан багт хүргүүлнэ.

5.Хүүхдийн эрх зөрчсөн, эсхүл эрсдэлт нөхцөлд байгаа талаар мэдээ, мэдээллийг хүлээн авсан ажилтан, албан тушаалтан тухайн мэдээллийг газар дээр нь шалгах, үнэлэх явцад хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюул шууд учирсан, эсхүл уг нөхцөл бүрдсэн, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийг түүнийг асран хамгаалах, харгалзан дэмжигч үйлдсэн, хүүхдийг тухайн орчинд үлдээх боломжгүй нөхцөл үүссэн бол яаралтай түр тусгаарлах арга хэмжээг эрх бүхий албан тушаалтанд тавьж, шийдвэрлүүлнэ.

6.Хүүхдийг түр тусгаарлах шийдвэр гарах хүртэл хугацаанд тухайн мэдээ, мэдээллийг хүлээн авсан нийгмийн ажилтан, албан тушаалтан хуульд заасан боломжит арга хэмжээг гэр бүлийн бусад гишүүн, хууль ёсны төлөөлөгчтэй зөвшилцөн хэрэгжүүлнэ.

7.Хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч тухайн хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэх үндэслэл байгаа бол энэ хуульд заасан тусгаарлах арга хэмжээг авахдаа тэдний зөвшөөрлийг шаардахгүй.

8.Гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй боловч эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаархи мэдээ, мэдээллийг нийгмийн ажилтан дангаар болон багаар газар дээр нь, эсхүл байгаа орчинд нь очиж үзэх, харилцан ярилцах хэлбэрээр шалгаж болно.

9.Энэ хуульд заасны дагуу ирүүлсэн мэдээ, мэдээлэл хүүхдийн эрхийн эсрэг зөрчлийн шинжтэй бол хүүхдийн эрхийн ажилтан холбогдох хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

10.Хүүхдийн эрхийн эсрэг гэмт хэргийг цагдаагийн байгууллагын алба хаагч холбогдох хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

11.Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхэд хамгааллын хамтарсан багийн ажил үйлчилгээ /15 дугаар зүйл/

1.Аймаг, дүүргийн Засаг дарга орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай зөвшилцөн хүүхдийн эрхийн хууль зүйн хороог байгуулах бөгөөд хороо нь дараахь үйл ажиллагаа явуулна.

1.1.гэмт хэрэг үйлдэж шүүхээс ял шийтгүүлсэн, хүмүүжлийн чанартай арга хэмжээ авагдсан хүүхдийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хүлээн авах, шүүхээс хүүхдэд даалгасан үүргийг биелүүлэхэд зөвлөгөө өгөх, дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

1.2.сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаад суллагдсан хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

1.3.гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдаж байгаа хүүхдийг эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны сөрөг нөлөөллөөс хөндийрүүлэх зорилгоор хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах, хүүхдэд батлан даагч томилуулахаар санал гаргах;

1.4.хууль зөрчсөн хүүхдийг зөв зохистой хүмүүжил олгох сургалт, хөтөлбөрт хамруулах;

1.5.эцэг, эх, гэр бүлийн гишүүд, үе тэнгийхэн, сургууль, хамт олонд нь зөвлөгөө өгөх, тогтмол хугацаанд уулзалт, ярилцлага зохион байгуулж, үр дүнг тооцох;

1.6.хорт зуршлаас ангижрах эмчилгээнд хамруулах, зөвлөгөө өгөх, ажил, сургууль, мэргэжил олгох сургалтад хамруулах;

1.7.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн үйлчлэлд хамаарахгүй хүүхдэд туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх, тэдний эрх ашгийг хамгаалах;

2.Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажлын албаны үүргийг орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн байгууллага хэрэгжүүлнэ.

3.Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хууль зүйн болон хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

4.Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар нөхцөл байдлын үнэлгээ хийж, цаашид тухайн хүүхдэд шаардлагатай үйлчилгээний талаар дүгнэлт, зөвлөмж гаргах, яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө өгөх чиг үүрэг бүхий тухайн шатны хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон сургуулийн нийгмийн ажилтан, өрхийн эмч, цагдаагийн ажилтан, бусад мэргэжилтний бүрэлдэхүүнтэй хамтарсан багийг сум, хорооны Засаг даргын захирамжаар байгуулан ажиллуулна.

5.Хамтарсан багийн ажиллах журам, тухайн багийн гишүүдэд урамшуулал олгох журмыг хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

V.Дөрөвдүгээр бүлэг **Хүүхэд хамгааллын хамтын ажиллагаа**

12.Төрийн байгууллагын хамтын ажиллагаа /17 дугаар зүйл/

1.Төрийн байгууллага хуульд заасан чиг үүргийн хүрээнд хүүхэд хамгааллын чиглэлээр дараахь үйл ажиллагаа явуулна.

1.1.хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхдээ тус тусын хуулиар заасан чиг үүргийг хэрэгжүүлэх, хамтран ажиллах;

1.2.хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүнээр тухайн байгууллагын алба хаагч, ажилтныг томилуулахаар санал болгох, үйл ажиллагааг нь дэмжих;

1.3.хүүхдийн үүсгэл санаачилгын байгууллага, элчийн үйл ажиллагааг дэмжих, хүүхэд оролцсон арга хэмжээ, үйл ажиллагаанд оролцож, хяналт тавих;

1.4.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлэх, хууль зөрчсөн хүүхдийг нийгмийн харилцаанд дасган зохицуулахад хамтран ажиллах.

13.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны, орон нутгийн байгууллагын үйл ажиллагаа /18 дугаар зүйл/

1.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь үйл ажиллагаа явуулах замаар хүүхэд хамгааллын үндэсний болон орон нутгийн тогтолцоог удирдан зохион байгуулна.

1.1.хүүхдийн эрхийн хэрэгжилтийн төлөв байдал, хүүхэд хамгааллын талаар хийсэн ажлыг Монгол Улсын Засгийн газар, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн өмнө хариуцан жил бүр тайлагнах;

1.2.нөхцөл байдлын үнэлгээ хийх, хариу үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах, үйл ажиллагааг нь дүгнэх;

1.3.хүүхэд хамгааллын сургалтын хөтөлбөр батлан хэрэгжүүлэх, хүүхдийн эрхийн талаар мэдлэг, мэдээллийг сайжруулах арга хэмжээг авах, хүүхэд хамгааллын чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил явуулах;

1.4.хүүхэд хамгааллын үйлчилгээний нэр төрөл, чанарыг дээшлүүлэх арга хэмжээг авах, мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний үндсэн дээр тухайн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулах;

1.5.хүүхэд хамгаалалд бүх шатны төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэн, гэр бүл, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааг дэмжих;

1.6.хүүхдийг гэр бүл, нийгмийн бүх орчинд эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах;

1.7.төрийн байгууллага, хуулийн этгээд, шүүх, прокурор, хууль сахиулах байгууллагын хүүхдийн асуудал хариуцсан ажилтан, алба хаагчид, үйлчилгээ үзүүлэгчдийг сургаж, мэргэшүүлэхэд холбогдох байгууллагатай хамтран ажиллах;

1.8.хууль сахиулах байгууллагатай хамтран хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил үйлдсэн иргэн, хуулийн этгээд, хууль зөрчигч хүүхэд, гэрч, хохирогч хүүхдийн талаар мэдээллийн сан бүрдүүлж үйл ажиллагаандаа ашиглах;

2.Хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага хүүхэд хамгааллын чиглэлээр дараахь үйл ажиллагаа явуулна:

2.1.нутаг дэвсгэрийн хэмжээнд хүүхэд хамгааллын талаархи мэдээлэл, судалгаанд нэгдсэн дүгнэлт хийж, цаашид хийх ажлын чиглэлийг тодорхойлох;

2.2.төрийн байгууллага, хуулийн этгээд, шүүх, прокурор, хууль сахиулах байгууллагын хүүхдийн асуудал хариуцсан ажилтан, алба хаагчдыг сургах, мэргэшүүлэх,

2.3.Хүүхдийн эрхийн тухай хууль болон энэ хуулийн хэрэгжилтэд гурван жил тутамд нэгээс доошгүй удаа анхан шатны хяналт шинжилгээ, үнэлгээ хийх;

18.2.4.нийгмийн ажилтан, хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэгчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

2.5.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаархи мэдээллийн сан бүрдүүлж үйл ажиллагаандаа ашиглах, бүртгэл, статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан аргачлалын дагуу эрдсэлт нөхцөлд байгаа хүүхдийн халамж, хамгаалал үйлчилгээний талаар бүртгэл хөтөлж, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

2.6.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хүүхэд харагчийг сайн дурын болон хуульд заасны дагуу шүүхийн шийдвэрээр албадан сургалтад хамруулах ажлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хамтран зохион байгуулах;

2.7.гэр бүлээсээ дайжсан, эсхүл эцэг, эх, асран хамгаалагчийн халамж анхаарал, хараа хяналтаас гадуур байгаа хүүхдийг бүртгэх, судалгаанд авах, гэр бүлд нэгтгэх ажлыг орон нутгийн Цагдаагийн байгууллагатай хамтран гүйцэтгэх.

14.Нийгмийн ажилтны эрх зүйн байдал /20 дугаар зүйл/

1.Орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан байгууллага нь нутгийн өөрөө удирдах байгууллагатай зөвшилцөн сум, дүүрэг, баг, хороонд хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан ажиллуулна.

2.Нийгмийн ажилтны ёс зүйн дүрэм, түүнд тавих шаардлагыг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн мэргэжлийн холбоодтой зөвшилцөн батална.

3.Нийгмийн ажилтан хүүхэд эрсдэлт нөхцөлд байгаа талаархи мэдээлийг хүлээн аваад тухайн газар дээр очиж шалгах, тухайн хүүхэдтэй нөхцөл байдлын талаар харилцан ярилцах, хуулиар хориглоогүй мэдээлэл цуглуулах эрхтэй.

4.Нийгмийн ажилтан өөрийн амь нас, эрүүл мэндэд аюултай нөхцөлд хүүхдэд эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээ хийх шаардлагатай болсон тохиолдолд *цагдаагийн байгууллагын* туслалцааг авна.

5.Нийгмийн ажилтныг ажиллах нөхцөл, боломжоор хангах үүргийг сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга хариуцна.

VI.Тавдугаар бүлэг

Хяналт, шинжилгээ, үнэлгээ, санхүүжилт

15.Хүүхэд хамгааллын хяналт, шинжилгээ, үнэлгээ /22 дугаар зүйл/

1.Хүүхэд хамгааллын нөхцөл байдлыг тодорхойлох, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлэх хариу үйлчилгээг үнэлэх зорилгоор хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь дараахь хяналт, шинжилгээ, үнэлгээ хийнэ:

1.1.орон нутаг, анхан шатны нэгжээс эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар бүртгэл, судалгааг нэгтгэн дүгнэх;

1.2.хууль зөрчсөн, гэмт хэргийн гэрч, хохирогч болсон хүүхдийн талаар бүртгэл, судалгааг цагдаагийн болон хууль сахиулах бусад байгууллагатай хамтран гаргаж, дүн шинжилгээ хийх;

1.3.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлсэн үйлчилгээ, түүний үр дүнг үнэлж, шалгах;

1.4.хүүхэд хамгаалалд төрийн байгууллагуудын оролцоог үнэлэх;

1.5.хүүхэд хамгааллын хүний нөөцийн бодлогыг төлөвлөн хэрэгжүүлэх, сургалтын чанар, үр нөлөөг үнэлэх;

1.6.хүүхэд хамгааллын чиглэлээр үйлчилж байгаа захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтийг үнэлж, дүгнэх;

1.7.Хууль тогтоомжийн тухай хуульд заасан аргачлалын дагуу Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэх.

VII.Зургадугаар бүлэг

Бусад зүйл

16.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага /24 дүгээр зүйл/

1.Хүүхдийн эрхийн зөрчилд хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуулиар³, хүүхдийн эсрэг гэмт хэрэгт оногдуулах ял, албадлагын арга хэмжээг Эрүүгийн хуулиар⁴ тус тус тодорхойлно.

ХУУЛИЙН ХЭЛТЭС

³ “Зөрчлийн тухай хууль”. “Төрийн мэдээлэл эмхэтгэл”. 2016 он. №08.

⁴ “Эрүүгийн хууль”. “Төрийн мэдээлэл эмхэтгэл”. 2016 он. №07.

**ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСНЫ
ДАГУУ ДАГАЛДАН ГАРАХ ЭРХ ЗҮЙН АКТ, БУСАД**

№	Журмын нэр	Батлах субъект
1	Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас магадлан итгэмжлэгдсэний үндсэн дээр үйл ажиллагаа явуулах журам батлах	Хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална./10.4/
2	Эрсдэлд байгаа хүүхдэд нөхцөл байдлын үнэлгээ хийх журам батлах.	Хүүхэд гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална. /12.5/
3	Нөхцөл байдлын үнэлгээ хийсэн, хариу үйлчилгээ үзүүлсэн нийгмийн ажилтан, хамтарсан багийн гишүүнд нэмэгдэл урамшуулал олгох журам батлах.	Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална. /12.6/
4	Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний стандарт, үйлчилгээ үзүүлэх журам батлах.	Стандартыг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, үйлчилгээ үзүүлэх журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус батална. /13.3/
5	Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам батлах.	Хууль зүйн болон хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.
6	Хамтарсан багийн ажиллах журам, тухайн багийн гишүүдэд урамшуулал олгох журам батлах.	Хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
7	Нийгмийн ажилтны ёс зүйн дүрэм батлах.	Тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн мэргэжлийн холбоодтой зөвшилцөн батална.

ТӨВ, ОРОН НУТГИЙН ЦАГДААГИЙН ГАЗАР,
ХЭЛТСИЙН ДАРГА НАР ТАНАА

Монгол Улсын Их хурлаас 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдөр баталсан “Хүүхэд хамгааллын тухай хууль”-ийн талаар гарын авлага бэлтгэн хүргүүлэв.

Алба хаагчдад сургалт явуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана уу.

Хавсралт хуудастай.

ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА,
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА

Л.НЯМДАВАА

АЛБАН БИЧГИЙН ТӨСЛИЙГ ХЯНАЖ
САНАЛ ӨГӨХ АЛБАН ТУШААЛЫН НЭРС

№	Газар, хэлтсийн дарга	Гарын үсэг /огноо	Нэр
1	Хуулийн хэлтсийн дарга		д/х Л.Нямдаваа
2	Боловсруулсан албан тушаалтан		х/ч Ч.Мөнхбат

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ХУУЛИЙН ХЭЛТЭС

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

2016 он

Гарчиг

Оршил.....	1-3
Нэгдүгээр бүлэг: Нийтлэг үндэслэл: Хуулийн зорилт.....	3-3
Хүүхэд хамгааллын зарчим, тогтолцоо	3-4
Хуулийн үйлчлэх хүрээ	4-4
Хуулийн нэр томъёоны тодорхойлолт.....	4-5
Хоёрдугаар бүлэг: Гэр бүл дэх хүүхэд хамгаалал	5-5
Эрүүл мэндийн үйлчилгээн дэх хүүхэд хамгаалал	5-5
Хэвлэл, мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгаалал	6-6
Олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээн дэх хүүхэд хамгаалал.....	6-6
Гуравдугаар бүлэг: Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ	7-7
Мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах	7-8
Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхэд хамгааллын хамтарсан багийн ажил... ..	8-9
Дөрөвдүгээр бүлэг: Хүүхэд хамгааллын хамтын ажиллагаа	
Төрийн байгууллагын хамтын ажиллагаа.....	9-9
Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны, орон нутгийн байгууллагын үйл ажиллагаа.. ..	9-10
Нийгмийн ажилтны эрх зүйн байдал.....	10-11
Тавдугаар бүлэг: Хяналт, шинжилгээ, үнэлгээ, санхүүжилт.....	11-11
Хүүхэд хамгааллын хяналт, шинжилгээ, үнэлгээ.....	11-11
Зургадугаар бүлэг: Бусад зүйл	
Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага.....	11-11